

## Уламжлалт анагаах ухааны их эмч

### Тестийн зөв хариулт

1-D, 2-D, 3-C, 4-E, 5-A, 6-A, 7-D, 8-A, 9-E, 10-A, 11-D, 12-E, 13-C, 14-C, 15-B, 16-A, 17-A, 18-B, 19-A, 20-B, 21-B, 22-A, 23-B, 24-C, 25-C, 26-B, 27-A, 28-C, 29-E, 30-E, 31-D, 32-B, 33-E, 34-D, 35-E, 36-C, 37-C, 38-E, 39-E, 40-B, 41-C, 42-B, 43-B, 44-E, 45-A, 46-A, 47-B, 48-A, 49-C, 50-D, 51-B, 52-B, 53-E, 54-D, 55-C, 56-C, 57-D, 58-D, 59-D, 60-D, 61-B, 62-B, 63-B, 64-C, 65-C, 66-A, 67-D, 68-D, 69-D, 70-A, 71-D, 72-D, 73-D, 74-B, 75-D, 76-C, 77-D, 78-A, 79-C, 80-E, 81-B, 82-D, 83-C, 84-A, 85-D, 86-D, 87-C, 88-A, 89-C, 90-A, 91-D, 92-A, 93-D, 94-C, 95-A, 96-C, 97-B, 98-C, 99-A, 100-A, 101-C, 102-A, 103-B, 104-A, 105-B, 106-B, 107-A, 108-B, 109-A, 110-D, 111-C, 112-A, 113-B, 114-A, 115-B, 116-A, 117-B, 118-E, 119-E, 120-A, 121-A, 122-B, 123-E, 124-C, 125-C, 126-E, 127-A, 128-A, 129-C, 130-A, 131-C, 132-A, 133-C, 134-E, 135-A, 136-A, 137-B, 138-C, 139-A, 140-A, 141-C, 142-C, 143-C, 144-E, 145-A, 146-C, 147-D, 148-C, 149-D, 150-E, 151-A, 152-B, 153-B, 154-B, 155-B, 156-B, 157-B, 158-E, 159-C, 160-B, 161-C, 162-A, 163-B, 164-C, 165-D, 166-D, 167-A, 168-B, 169-D, 170-C, 171-D, 172-E, 173-C, 174-C, 175-C, 176-E, 177-B, 178-D, 179-B, 180-A, 181-B, 182-D, 183-D, 184-A, 185-E, 186-C, 187-A, 188-A, 189-B, 190-B, 191-C, 192-A, 193-C, 194-B, 195-A, 196-B, 197-D, 198-B, 199-D, 200-D, 201-D, 202-B, 203-B, 204-E, 205-D, 206-B, 207-B, 208-C, 209-E, 210-A, 211-B, 212-A, 213-E, 214-C, 215-D, 216-C, 217-A,

Тестийн түлхүүр

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дүгээр хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

Сонгогдсон сорил

/1./ Хэхрүүлэх, хоосон огих, базалж өвдөх, хоржигнож суулгах нь ходоодны ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу

A. Ходоодны бадган

B. Ходоод тэлэгдэх

C. Ходоод доройтох

D. Ходоодны хий

E. Ходоодны шар

/2./ Хэлний дунд хэсэгт зузаан шар өнгөртэй байх нь ямар өвчний шинж болохыг тогтооно уу

A. Хий

B. Бадган

C. Цус

D. Шар

E. Шар ус

/3./ Бор ходоодонд оршвол ямар өвчний шинж үзүүлхийг тогтооно уу

A. Шарын

B. Хийний

C. Бадгана

D. Цусны

E. Шар усны

/4./ Бөөрний гэмтсэн халууны шинжийг сонгоно уу

A. Явж суусны дараа бөөрөөр хатгаж өвдөх

B. Шээс чавдагшрах

C. Өглөө босоход зовхи сэлхрэх

D. Шээсний уур арилах нь удаан, язмаг нь хэсэглэн хуйлрах

E. Шээс нь улаан язмагтай

/5./ Зогисох өвчний өвчин зүйн хувиралтыг тогтооно уу?

A. Дээш гүйгч хийн сүв хаагдах

- V. Гал сацуу хийн гүйх сүв хаагдах
  - C. Мэдрэхүйн сүв хаагдах
  - D. Бадгана салс арвидаж, уруу арилгагч хийн гүйдэл хаагдах
  - E. Амь баригч хийн гүйдэл хаагдах
- /6./ Эмчийн зүүн гарын долоовор хуруунд эмэгтэйн ямар эрхтэний судас оношлогдохыг тогтооно уу
- A. Зүрх гэдэс
  - B. Элэг цөс
  - C. Бөөр давсаг
  - D. Уушги олгой
  - E. Дэлүү ходоод
- /7./ Суваг хавангийн ерөнхий шинжийг олно уу
- A. Түргэн хугацаанд хавагнана
  - B. Хаван өлмийнөөс эхэлнэ
  - C. Хэвлий томорно
  - D. Хэвтсэн тал руу хаван шилжинэ
  - E. Нимгэн газраар хавагнах
- /8./ Элэгний хар хэрх өвчний үед илрэх шинж тэмдгийг олно уу?
- A. Ууц нуруугаар хүчтэй өвдөх
  - B. Аюулхайн баруун хэсэгт өвдөх
  - C. Аюулхайн үзүүрт өвдөх
  - D. Цээжээр хатгуулах
  - E. Ходоод цанхайх
- /9./ Увдисын үндэсний 90 - р бүлэгт өтлөгсдийг тэнхрүүлэх тухай номлосон байдаг. Түүний тус эрдмийг юу гэж заасан болохыг тогтооно уу
- A. Хордлого тайлах, өвчнийг анагаах, дур хүслийг бий болгох
  - B. Нянг нядлах, хурсныг арилгах, тамиржуулах, идээнд дуртай болгох
  - C. Хөлөргөх, шээлгэх, амьсгал уужруулах, сэтгэл санаа тайвшруулах
  - D. Цөв хирийн ялгаралтыг сайжруулах, ундаасахыг багасгах, суулгалтыг зогсоох, халуун бууруулах
  - E. Урт наслуулах, залуужуулах, өнгө хүчийг нэмэгдүүлэх, оюун ухааныг хурц болгох
- /10./ Цөв эс шингэсэн идээний бэтэг ямар эрхтэнд үүсдэг болохыг тогтооно уу
- A. Ходоод
  - B. Гэдэс
  - C. Элэг
  - D. Цөс
  - E. Дэлүү
- /11./ Боловсроход бэрхтэй халууны шинжийг тогтооно уу
- A. Хөхүүлж ханиах
  - B. Нүүр улайх
  - C. Судас эрчимтэй, хоосон бөгөөд түргэн
  - D. Нүдний харц дээшээ болж нулимс гоожих
  - E. Бусад халууныг бодвол хоолны дур сайн
- /12./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Номлохуйн үндэс”-т заасанчлан дээш гүйгч хий өвчний үе дэх эм уух ёсыг сонгоно уу?.
- A. Идээ эс идсэн цагт
  - B. Идээний өмнө
  - C. Идээний дунд
  - D. Идээний эцэст
  - E. Идээний завсарт
- /13./ Усан хаван өвчний судас хэрхэн лугшихыг тогтооно уу
- A. Бүдүүн чанга лугших
  - B. Хүч бага хөвч нарийн лугших

- C. Нарийн живэнги доороо чанга лугших
  - D. Цон дээр сулхан лугших
  - E. Доороо сул лугших
- /14./ Цусны өвчнийг орноор нь юу гэж ангилдгийг тодорхойлно уу
- A. Арьсанд тархах маханд дэлгэрэх
  - B. Ясанд шунах, цулд буух
  - C. Цээжинд дэлгэрэх, завсарт орших, бөгсөнд унах
  - D. Саванд унах
  - E. Үесэнд сарних
- /15./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Язгуурын үндэс” дэх “ялж төгс нөхцсөн” гэснээс зөвхөн “ялж” гэсэн үгийн утгыг хэрхэн тайлбарладаг вэ?. Хариуг сонгоно уу?
- A. эрх баялаг, сайхан дүрс, цог төгөлдөр, алдар, билэг (билгүүн), хичээнгүй зэрэг 6 (сайн) хотол чуулган төгссөн гэсэн утгатай юм
- B. 4 шулмыг (тэнгэрийн хөвгүүн шулам, нисванисын шулам, үхлийн эзний шулам, цогцын шулам зэрэг дөрөв) эсвэл нисванисын үйл, төрлийн үйл, нисванисын түйтгэр, мэдэгдэхүүний түйтгэр зэрэг дөрвийг буюу үл зохилдох бүгдийг дарсан
- C. мэдэгдэхүүнүүдийн мөн чанар, ёсыг ямар мэт болгоон залардаг гэсэн утгатай юм
- D. гаслан, зовлонгийн хязгаараас салсан буюу эсвэл 6 сайн нь Асарт (6 зүйл амьтны нэг) байдаг ч бурханд байх нь 6 баримадын эцэст хүрсний тэмдэг мөнөөр ертөнцөөс хэтэрсэн гэсэн утгатай
- E. танин барилтаар хурсан түйтгэр, муу авьяас сэлтийн дайсныг дарсан гэсэн утгатай юм
- /16./ Бөөрний сувагт унах өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу?
- A. Өвдөг өлмий хавдах
  - B. Цусаар шээх
  - C. Бэлхүүсээр муруйх
  - D. Сүүжний нүхээр эвэршээх
  - E. Хөлөө чирэх
- /17./ Халуунаар булингартах үеийн ерөнхий шинж ямар байхыг тогтооно уу
- A. Тамир дорой,хөдөлбөл зүрх дэлсэх
  - B. Нойр их байх
  - C. Зүрхээр хатгах
  - D. Хэл, буйл улайх
  - E. Ханиах нь олон
- /18./ Бие махбод хордож, шүд ,хумс өвдөх үесийн голоор шимшрэн өвдөх зэрэг шинж тэмдгүүд 7 н тамирын боловсролтын аль үе шат алдагдсан болохыг тогтооно уу
- A. Цуснаас мах боловсрох үе
  - B. Яснаас чөмөг боловсрох үе
  - C. Чөмөгнөөс дусал боловсрох үе
  - D. Махнаас өөх боловсрох үе
  - E. Өөхнөөс яс боловсрох үе
- /19./ Эрүү түүш сулрах язгуурын хий өвчний үед гарах шинжийг олно уу?
- A. Шүд зуурах, эрүү унжих
  - B. Хуйхны өнгө харлах
  - C. Шилбэ хөших
  - D. Хавирга сүврэгээр хатгах
  - E. Хэсч хатгах
- /20./ Уруул өнгөө алдаж цайх нь ямар өвчний шинж болхыг тогтооно уу
- A. Хий өвчин
  - B. Цайвар хаван
  - C. Дэлүү цусаар хөөх
  - D. Дэлүүний суулгах
  - E. Дэлүүний халуун

- /21./ Мүгво олгойд унасан үед ямар өвчний шинж илрэхийг тогтооно уу
- A. Шарын
  - B. Хийний
  - C. Бадгана
  - D. Цусны
  - E. Шар усны
- /22./ Шимжүүлэх жүдлэнг ямар насны хүмүүст хэрэглэвэл үр дүнтэй болохыг тогтооно уу
- A. Настай хүмүүст
  - B. Залуу хүмүүст
  - C. Хүүхдэд
  - D. Элэгний өвчтэй хүмүүст
  - E. Бөөрний өвчтэй хүмүүст
- /23./ Тасралтгүй ханиалгаснаас нүүр нүд минчийж улайх, амьсгал боогдох, цэр гарвал бага зэрэг тайвшрах шинж гардаг уушигны ямар өвчин байдгийг тогтооно уу.
- A. Уушигны дагшуур
  - B. Огшрон ханиах
  - C. Уушиг дэлгэрэх
  - D. Их архаг
  - E. Хаван
- /24./ Халууны хүч туйлын их үед өгөх тан эмийг сонгоно уу?
- A. Хүч ихтэй бол дэгд нэмж өгөх
  - B. Хүч багатай бол хонилон нэмж өгөх
  - C. Хүч ихтэйд гавар -3 өгөх
  - D. Хүч дунд бол гиван 8
  - E. Хүч бага бол гавар нэмж өгөх
- /25./ Зүрхний гэмээр хоолонд дургүй болох үед сэтгэл санаа тогтворгүй болох зүрх орчмоор хатгуулах амьсгал давхцах зэрэг шинж илэрдэг. Энэ шинж нь ямар махбодийн хямрал болохыг сонгоно уу
- A. Шар
  - B. Бадгана
  - C. Хий
  - D. Цус
  - E. Хий, шар
- /26./ Эмчийн зүүн гарын дунд хуруунд эрэгтэйн ямар эрхтэний эмгэг илрэхийг тогтооно уу
- A. Зүрх гэдэс
  - B. Элэг цөс
  - C. Бөөр давсаг
  - D. Уушги олгой
  - E. Дэлүү ходоод
- /27./ Усан хаван өвчний нөхцөл аль болохыг тогтооно уу
- A. Туулга өгсний дараа идээ явдал буруудсан
  - B. Хануур хэтрэх
  - C. Давслаг амттай хоол ундыг хэтрүүлэх
  - D. Биеийн хүчний хүнд ажлын дараа ус их уусан
  - E. Хоосорсон халууныг ханасан
- /28./ Ходоод доройтсон өвчний үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу?
- A. Тасралтгүй өвдөнө
  - B. Хоолны дур хаагдана
  - C. Шимтэй идээ шингэхгүй
  - D. Залгиур өвдөнө
  - E. Шар ногоон зүйлээр бөөлжинө

/29./ Өвчтөн 72 настай сүүлийн үед хоол унд идээд цаддаггүй , хоол унд идээд тэр даруйдаа суулгадаг гэсэн зовиуртай эмчид хандсан. Үзэхэд маш их турж эцсэн, хэвлий цардайж томорсон, тамир тэнхээ муутай байлаа та оношоо тогтооно уу

- A. Аюулхайн бадган
- B. Галын илч буурсан бадган
- C. Цагаан хэрх бадган
- D. Хоолой хаагдах бадган
- E. Шингэн хатаагч бадган

/30./ Цөв эс шингэснээс шалтгаалж үүсэх бэтэг аль болохыг тогтооно уу

- A. Чулуун бэтэг
- B. Өгөрийн бэтэг
- C. Цусан бэтэг
- D. Хорхойн бэтэг
- E. Аюулхайн бэтэг

/31./ Цус шарын хувь дийлэнхи эс боловсорсон халуун өвчин цаашдаа ямар өвчинд шилжиж болохыг тогтооно уу

- A. Хоосорсон
- B. Булингартсан
- C. Хямарсан
- D. Хуучирсан
- E. Хорын халуун

/32./ Хөврөл тогтоход усан махбод нь ямар үйлдэлтэй болохыг тодорхойлно уу

- A. бүрдэх
- B. хурах
- C. боловсрох
- D. бойжих
- E. бойжих суурь болох

/33./ Хүйтнээр суулгах өвчний судас яаж лугшихыг тогтооно уу

- A. Бүдүүн чанга лугших
- B. Хүч бага хөвч нарийн лугших
- C. Нарийн живэнгүй ёроолдоо чанга лугших
- D. Цон дээр сулхан лугших
- E. Доороо сул лугших

/34./ Цусны өвчнийг эмчилэхэд ямар жорыг гол болгон сонгодог болохыг тодорхойлно уу?

- A. Гүргэм 7
- B. Зандан 3
- C. Дэгд 8
- D. Хонилон4
- E. Жуган 8

/35./ Гэмийн, орны үүднээс ангилсан ангилалд багтах өвчнийг сонгоно уу?.

- A. сэтгэлд орших өвчин
- B. дунд биед орших өвчин
- C. дээд биед орших өвчин
- D. хоолойд орших өвчин
- E. таван эрхтэнд орших

/36./ Шанбарам өвчний үед ямар хий хямрахыг тогтооно уу

- A. Дээш гүйгч хий
- B. Гал сацуу хий
- C. Уруу арилгагч хий
- D. Амь баригч хий
- E. Түгмэл гүйгч хий

- /37./ Төмөр хагт бадган өвчний шинжий тогтооно уу
- A. Хар шүлс асгарах
  - B. Дусал цувирах
  - C. Турж эцэх
  - D. Шим үл авах
  - E. Суваг хаван болох
- /38./ Шүд хумсанд хар толбо тогтвол ямар өвчний шинж болхыг олно уу
- A. Бие шарлах
  - B. Элэг бүдүүрэх
  - C. Элэгний бор
  - D. Элэгний цанх
  - E. Бие харлах шар
- /39./ Эрлэгийн элчид баригдсан мэт хэмээн үздэг шарын өвчнийг тодорхойлно уу
- A. Бие шарлах
  - B. Нүд шарлах
  - C. Цусанд шар унах
  - D. Элгэнд шар дэлгэрэх
  - E. Бие харлах шар өвчин
- /40./ Нуруу бүсэлхийгээр тасрах мэт өвдөх, ходоод цанхайж хоолны шингээлт муудах, ууц нуруугаа даахгүй болох, хэвлийн доод хэсгээр тасралтгүй өвдөж шээс боогдоно. Ямар бэтэг өвчний шинж болохыг тогтооно уу
- A. Савны усан бэтэг
  - B. Цусан бэтэг
  - C. Махан бэтэг
  - D. Булчирхайн бэтэг
  - E. Судасны бэтэг
- /41./ Дагшуур хүрснээс олон ханиалгадаг байсан. Сүүлийн үед ам заваарах, биеийн тамир суларч, турж эцэх, зүрх дэлсэх, амьсгаа давчдах, хавагнах, дотор муухайрч бөөлжис цутгах шинж илрэх болсон. Ямар өвчин болохыг тогтооно уу
- A. Уушгины архаг
  - B. Уушгины хаван
  - C. Барагдуулагч их архаг
  - D. Сурьяа
  - E. Уушгины брай
- /42./ Эмийг халууны хүчинд нь хэрхэн уялдуулж өгөхийг сонгоно уу
- A. Халууны хүч дунд бол гүргэм 8
  - B. Халууны хүч их бол гавар 9
  - C. Халууны хүч бага бол гиван 8
  - D. Ямар ч үед зандан 8
  - E. Ямар ч үед банздоо 12
- /43./ Хоолонд дургүй болох өвчний үед эхүүн амттай эмт усыг хэрэглэх тухай заасан байдаг. Үүнийг дотрын өвчний тайлбар зохиолд юу гэж дэлгэрүүлсэн болохыг сонгоно уу
- A. Ар үрийн шүүс
  - B. Ар үр , бар үрийн шүүс
  - C. Жүр үрийн шүүс
  - D. Өмхий давсны шүүс
  - E. Анарын шүүс
- /44./ Судасны эн нарийн дарахад зогсохгүй эрчилсэн утас шиг хүчтэй лугшдаг нь ямар судас болхыг тогтооно уу
- A. Хатуу
  - B. Дэлгэрэнгүй

- C. Хуйларсан
  - D. Түргэн
  - E. Эрчимтэй
- /45./ Цусан сарнилтын усан хаван өвчний үүсэх ёсыг тогтооно уу
- A. Эс шингэсэн тунгалаг элгийг дамжихдаа тунгалаг болж чадаагүй
  - B. Эс шингэснээр ходоодонд бадган салс цугларсан
  - C. Уруу арилгагч хийн мөр хаагдаснаас шээс тунгалгийн гүйх сүвэнд орсон
  - D. Шээс тунгалгийн мөрт алддагдсан
  - E. Цус цалгисан
- /46./ Олгойн хүйтнээр хөөх өвчний үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу?
- A. Хөөстэй цайвар зүйлээр суулгах
  - B. Идээний хольцтой зүйлээр суулгах
  - C. Нүүр царай борлох
  - D. Халуурах
  - E. Нурууны голоор хөшиж өвдөх
- /47./ Шинар-6 ходоодны ямар өвчний гол ерөндөг болохыг тогтооно уу
- A. Ходоодны борын улмаас бөөлжих
  - B. Ходоодны шараас болж бөөлжих
  - C. Ходоодны хор харших
  - D. Ходоодны бадганаас болж бөөлжих
  - E. Ходоодны хийгээс болж бөөлжих
- /48./ Бэтгийн судасны лугшилтын онцлогийг тодорхойлно уу
- A. Сул балархай
  - B. Бүдүүн ган нь балархай
  - C. Живэнгэ алгуур дорой
  - D. Хөндий хоосон
  - E. Нарийн
- /49./ Ерийн халуун өвчний шалтгааныг тодорхойлно уу?
- A. Хэмжээнээсээ хэтэрсэн халуун шар
  - B. Ерөнхий шар судсанд гүйх
  - C. Дүр эс урвасан шар
  - D. Өнгө урвуулагч шар
  - E. Өнгө тодорхойлогч шар
- /50./ Ясны чихига өвчний үед буйланд гарах өөрчлөлтийг сонго?
- A. Буйл цайх
  - B. Буйл улайж хагарах
  - C. Буйл улайж хавдах
  - D. Буйл муухай үнэртэй болох
  - E. Буйл хар хөх болох
- /51./ Судас эс бүрдсэний шинжийг юугаар тодорхойлж болхыг тогтооно уу
- A. Судасны лугшилтаар
  - B. Эрхтэний цэцгээр
  - C. Өвчний шээсээр
  - D. Судасны хувиралтаар
  - E. Гарах хирээр нь
- /52./ Суман мод 6 танг цусны өвчний ямар хэлбэрийн үед гол болгон сонгохыг тодорхойлно уу
- A. Цус хөөрөх
  - B. Цус царцах
  - C. Цус барагдах
  - D. Цус гоожих
  - E. Цус 3 гэмд хорлогдох



/53./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиол дахь “...үзэхүй, сонсохуй, авахуй бөгөөд бүгдийг дадан суралцаж сэтгэлийг тэвчин үйлд” гэсэн тодорхойлолт эмчийн ямар үйлд хамааралтай болохыг сонгоно уу.

- A. өөрийн үйлд хичээх-шалтгаанд суралцах
- B. өөрийн үйлд хичээх-нөхцөлийг шүтэх
- C. өөрийн үйлд хичээх-нөхөрт хичээж үйлдэх
- D. бусдын үйлд хичээх
- E. өөрийн үйлд хичээх- сурахыг эцэст хүргэх

/54./ Бөөр доргисон гэм дээд биед сарнивал ямар шинж тэмдэг илрэхийг сонгоно уу

- A. Сүүжний нүхээр хатгуулж өвдөнө
- B. Хөлөө чирэх
- C. Нуруугаар өвдөх
- D. Судас нь эрчимтэй
- E. Цусаар шээх

/55./ Булингартсан халуун элгэнд буувал ямар шинж илрэхийг тогтооно уу

- A. Хэвлийгээр хатгуулах
- B. Элэгний судал бүдүүн чанга
- C. Нүд уруул шарлаж, дур хаагдан, хэл хөх эрээн болох
- D. Хэл цайвар, зузаан шар өнгөртэй болж, шараар суулгах
- E. Хэл хуурай ширүүн болох

/56./ Гүвдрүү нь шүр олмостой адил бөгөөд маш их халуурч өвдөх, цус элбэг гарах зэрэг шинж нь ямар хэлбэрийн шамбарам өвчний үед илрэхийг сонгоно уу

- A. Хийн шамбарам
- B. Шарын шамбарам
- C. Цусны шамбарам
- D. Бадганы шамбарам
- E. Хурмалын шамбарам

/57./ Ерөндөг – 7 жорыг аль өвчинд тохирхыг сонгоно уу?

- A. Шар бадгана өвчин
- B. Аюулхайн бадган өвчин
- C. Барилдуулагч бадганы гэмд
- D. Бор бадгана өвчин
- E. Галын илч буурсан бадган өвчинд

/58./ Бадган өвчний шээсний хувирах ёсыг тогтооно уу?

- A. Ёроолоосоо хувирна
- B. Дундаасаа хувирна
- C. Хувирахгүй
- D. Дээд гүехэн талаасаа хувирна
- E. Голоосоо хувирна

/59./ Толгой өвдөх, архи уувал улам хүчтэй хатгаж өвдөх, нүд шарлах, холын хараа муудах нь ямар шарын үед илрэх шинж болохыг тогтооно уу

- A. Шингээгч шар
- B. Өнгө урвуулагч шар
- C. Бүтээгч шар
- D. Үзүүлэгч шар
- E. Өнгө тодруулагч шар

/60./ Хэнхдэг цээжний цагаан судасны өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу ?

- A. Сэтгэл санаа үймрэх
- B. Дуу чимээнд өвчин нэмэгдэх
- C. Хөл бадайрах
- D. Үе мөч татах

Е. Ухаан алдах

/61./ Гурван төрлийн жүдлэнгийн хэлбэрээс үр залгах жүдлэнг ямар хүнд өгөхийг тогтооно уу

- A. Жирэмсэн эмэгтэйчүүдэд
- B. Хүүхэд гарахгүй хүмүүст
- C. Эмэгтэйчүүдийн өвчин
- D. Бөөрний өвчтэй хүмүүст
- E. Элэгний өвчтэй хүмүүс

/62./ Хэвлий томорч судсууд гүрвийж тодрон үе мөч нь нарийсч хатингартан , турж эцэх шинж гарах нь ямар эрхтэний усан хаван болохыг тогтооно уу?

- A. Бөөр
- B. Элэг
- C. Уушги
- D. Дэлүү
- E. Зүрх

/63./ Эс шингэсэн өвчинд шар хавсарвал илрэх шинж тэмдгийг олно уу?

- A. Шүлс наалдамхай болох
- B. Их ундаасах, хэхрэх
- C. Бие чичрэх
- D. Идээ ундааны амтыг үл мэдэх
- E. Бөөлжих

/64./ Гэдэс хаагдах өвчин ямар шалтгаантай болохыг тогтооно уу?

- A. Бадган хий
- B. Нян хорхой
- C. Цус шар
- D. Шар ус
- E. Цус

/65./ Бэтэг эвдрэх үед ямар шинж гарахыг тогтооно уу?

- A. Судас шээсэнд хүйтний шинж илрэх
- B. Ам хатах, дуршил буурах
- C. Зөөлөрч өвдөлт багасах, судас шээсэнд халууны шинж илрэх
- D. Толгой өвдөх , бөөлжих
- E. Цусаар суулгах, ам гашуурах

/66./ Ерийн халуун өвчний дотор шинжийг хэрхэн тодорхойлохыг тогтооно уу

- A. Судас нь дэлгэрэнгүй, эрчимтэй
- B. Нэг газар хүчтэй хатгуулна
- C. Исгэлэн гашуун амт амтагдах
- D. Судас нь дорой
- E. Толгой хүчтэй өвдөнө

/67./ Өвчний халуун хүйтний мөн чанарыг ялган оношлоход шээсний шинжилгээнд юуг голлон анхаарах ёстойг олно уу

- A. Үнэр
- B. Уур
- C. Өнгө
- D. Язмаг
- E. Хөөс

/68./ Хэсэг газарт хүйт оргих цайх мэдээгүй мэт санагдах, судасны лугшилт нь хүчгүй гүйхэд бэрхтэй байвал ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу?

- A. Цус барагдах
- B. Цус хөөрөх
- C. Цус алдах
- D. Цус царцах

- Е. Муу цусны өвчин
- /69./ Доорх бэлгэ чанаруудаас аль нь галын илчийн сурвалж болох вэ?
- А. хурц
  - В. тослог
  - С. хөнгөн
  - Д. халуун
  - Е. чийрэг
- /70./ Бөөрний ус алдах өвчний шинжийг олно уу?
- А. Цусаар шээх
  - В. Өлмий хавдах
  - С. Чих дүлийрэх
  - Д. Шээс чавдагшрах
  - Е. Шээс задгайрах
- /71./ Булингартсан халууны эмчилгээний зарчмыг тогтооно уу?
- А. Эхлээд зөрөлдөөнийг эвлүүлэх мэт
  - В. Түргэн ханаж , халууныг уурыг гаргах
  - С. Дунд үед нь ерөндгийн хүчинд тохируулах
  - Д. Шар усыг хатаасны дараа хануур, туулга хэрэглэх
  - Е. Эхлээд хэвлийн туулга хэрэглэх
- /72./ Мөнгөн ус дараах хорын өвчний аль ангилалд багтахыг тогтооно уу
- А. Чулууны хор
  - В. Махны хор
  - С. Бодьтой хор
  - Д. Эрдэнийн хор
  - Е. Өвсөн найруулгын хор
- /73./ Хутгаар хэрчих мэт өвдөлт зүрхний ямар өвчний үед илэрдгийг тогтооно уу
- А. Хий хатгалга
  - В. Цусан хатгалга
  - С. Халуун дэлгэрэх
  - Д. Халуун үймэлзэх
  - Е. Шарын хатгалга
- /74./ Гадар шинж нь халуун, мөн чанар нь хүйтэн өвчний шээсний хөөсөнд гарах шинжийг тогтооно уу?
- А. Хөөс их
  - В. Хөөс удаан арилах
  - С. Хөөс түргэн арилах
  - Д. Хөөсгүй
  - Е. Хутгавал бага зэрэг хөөсрөх
- /75./ Эмчилгээний үр дүнд нүд, шээс , нүүрний өнгө урьдахаас цайж, ундаасах, идээнд дургүй болох шинж нь арилахгүй байвал ямар засал, үйл хийвэл үр дүнтэй болохыг тогтооно уу
- А. Ханах
  - В. Бөөлжүүлэх
  - С. Жин
  - Д. Туулгах
  - Е. Усан засал
- /76./ Раднаа судас гэмтсэн үед илрэх шинжийг сонгоно уу
- А. Хөл татаж хөших
  - В. Сүүж бэлхүүсээр хөшнө
  - С. Нүүр ам муруйна
  - Д. Тал бие бадайрна
  - Е. Судас эрчимтэй

- /77./ Зүрхний цусан хатгалга өвчний хүндрэл нь аль болохыг тодорхойлно уу
- A. Ам муруйх
  - B. Хий цусаар дээш хөөрөх
  - C. Солио
  - D. Зүрх цусаар дүүрэх
  - E. Ухаан алдах
- /78./ Элэгний халуунд ямар эмчилгээ хийхийг тогтооно уу
- A. Башига, балига, гүргэм, дэгд өгч рүтүн ханах
  - B. Талх эм 3 үр өгөх
  - C. Домти өгөх
  - D. Гиван өгөх
  - E. 3 улааны тан өгөх
- /79./ Таван үндэсний тосон эмийг ямар эрхтэний жүдлэнд өгөхийг тогтооно уу
- A. Уушиг
  - B. Элэг
  - C. Бөөр
  - D. Зүрх
  - E. Дэлүү
- /80./ Чанга судасны эсрэг ямар судас байдгийг олно уу
- A. Живэнги
  - B. Сулхан
  - C. Балархай
  - D. Алгуур
  - E. Хоосон
- /81./ Усан хаван өвчнийг 5 үндсэн зарчмаар эмчилдэг. Бонагийн жорыг аль зарчмын дагуу сонгохыг тогтооно уу
- A. Сувгийн усыг замд нь оруулах мэтээр анагаах
  - B. Хавангийн усыг оронд нь хатаах мэт засах
  - C. Туулгаар засах
  - D. Нуурын усыг горхилон татах мэт засах
  - E. Судасны хавцлыг боож төөнөх
- /82./ Эс шингэснээс үүсдэг шинэ архаг өвчнүүдийг тодорхойлно уу?
- A. Ходоод тэлэгдэх
  - B. Бэтэг
  - C. Цайвар хаван
  - D. Аюулхайн бадгана
  - E. Барагдуулагч их архаг
- /83./ Гэдсэнд ямар хэлбэрийн бор илүү тохиолдхыг тогтооно уу
- A. Хуйлрах
  - B. Нуугдах
  - C. Дэлгэрэх
  - D. Сарних
  - E. Эс нуугдах
- /84./ Тунгалаг эс шингэсэн өвчин цаашид цувирах хэлбэрээр архагшвал ямар өвчин болж хүндрэхийг тогтооно уу
- A. Цайвар хаван , усан хаван
  - B. Суваг хаван, уяман
  - C. Суръяа,тулай,судасны бэтэг
  - D. Бам,хор, судасны бэтэг
  - E. Мүгво дэлгэрэх, дэлүүний өвчин
- /85./ Цусны халууны шинжийг олно уу?

- A. Бага зэрэг хавагнах
  - B. Ам нь гашуурч, нүд, шээс шарлах
  - C. Бие хүндэрч хоол муу шингэх
  - D. Нүд шээс улайх
  - E. Хэсэж хатгуулах
- /86./ Муу цусны гэм дийлэнх шанбарам өвчний шинжийг олно уу?
- A. Хуурайших
  - B. Гүвдрүү нь алаг
  - C. Атираа сулрах
  - D. Гүвдрүү нь шүр мэт
  - E. Хорхой ихсэх
- /87./ Эрүүл шээсний уурын замхралтын онцлогийг тогтооно уу
- A. Удаан арилдаг
  - B. Түргэн арилдаг
  - C. Удаан түргэн тэнцүүхэн
  - D. Уур ихтэй байдаг
  - E. Уур багатай байдаг
- /88./ Хар шар усны өвчий шалтгааныг тогтооно уу
- A. Шар ус цус шарын халуунд хорлогдох
  - B. Шар ус, бадгана
  - C. . Шар ус, хий
  - D. Шар ус, хорхой
  - E. Шар ус, шар , бадгана
- /89./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Номлохуйн үндэс”-т заасанчлан гал тэгшитгэгч хийн өвчний үе дэх эм уух ёсыг сонгоно уу?.
- A. Идээ эс идсэн цагт
  - B. Идээний өмнө
  - C. Идээний дунд
  - D. Идээний эцэст
  - E. Идээний завсарт
- /90./ Элэг дэлгэрэх өвчний шлтгаан аль болохыг тогтооно уу
- A. Шар
  - B. Бадгана
  - C. Хий
  - D. Цус
  - E. Хорхой
- /91./ Халуун булингартсанд тохирх эмчилгээг сонгоно уу
- A. Эхэнд нь бөөрөлзгөнө 3 тан өгнө
  - B. Дараа нь чацаргана 5 өгч цэрийг татах
  - C. Дунд нь сэндэн 9 өгч шар усыг хатаана
  - D. Сүүлд нь гавар 25 өгч сүүлийг хураах
  - E. Үр дүн муутай бол 3 үрийн үргэлжийн туулга өгнө
- /92./ Брай өвчний судас яаж лугшихыг тогтооно уу
- A. Нарийн чичэрч лугших
  - B. Хөндий хоосон лугших
  - C. Чанга лугших
  - D. Бүдүүн дүүрэн лугших
  - E. Живэнгэ дорой лугших
- /93./ Элэгний үхэр бөгтөр өвчний үед гарах шинж аль болохыг тодорхойлно уу
- A. Цээж дүүрч хуурай ханиах
  - B. Халуун исгэлэн усаар бөөлжих

- C. Даарсан үед зогсох
- D. Бие хавагнах
- E. Цусаар бөөлжих

/94./ Аюулхайн хэсэгт хөөж үе үе суулгах, нүүр цоохор болох нь ямар эрхтэний эмгэг болхыг тогтооно уу

- A. Цөс
- B. Давсаг
- C. Дэлүү
- D. Ходоод
- E. Самс

/95./ Хэл алаг болох, цусаар суулгах, хэвлийн хөөх, цанхайх, зүүн хөл хавдах нь ямар эрхтэнд шар буусны шинж болохыг тодорхойлно уу

- A. Дэлүү
- B. Элэг
- C. бөөр
- D. Ходоод
- E. Зүрх

/96./ Хүйтэн чанартай цагаан судасны өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу?

- A. Шээс тунгалаг хөөс жижиг
- B. Биеийн илч арвидах
- C. Судас нарийн түргэн
- D. Шээс нь үнэр уур их
- E. Судас алгуур зөөлөн эрчимтэй

/97./ Хэл нь хуурай , ширүүн, өнгөргүй богино болох нь зүрхний ямар өвчний үед тохиолдож болохыг тодорхойлно уу?

- A. Зүрхний халуун дэлгэрэх
- B. Зүрхэнд халуун үймэлзэх
- C. Зүрхэнд халуун нуугдах
- D. Зүрхний хатгалга
- E. Зүрхний шар ус

/98./ Халууны хоосон яаж үүсхийг сонгоно уу

- A. Гол судсанд халуун бууснаас үүснэ
- B. Халуун барагдаж хий арвидсанаас
- C. Халууны сүүлийг хийгээр үлээснээс
- D. Хий дийлэнх эс боловсорсон халуунд хануур туулга эс хэрэглэснээс
- E. Намрын цагт үүснэ

/99./ Жүрүрийн тан өгч жорган судсыг ханах нь дуу хаагдах өвчний ямар хэлбэрт илүү тохирхыг тогтооно уу

- A. Цусаар дуу хаагдах
- B. Шараар дуу хаагдах
- C. Бадганаар дуу хаагдах
- D. Хийгээр дуу хаагдах
- E. Өөхнөөс дуу хаагдах

/100./ Хий өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Хөндий хоосон үе үе зогсох
- B. Нарийн эрчимтэй
- C. Живэнгүй дорой
- D. Товоиж хуйлрах
- E. Чичирч гүйхэд бэрх

/101./ Эс шингэсэн өвчний шалтгааныг тодорхойлно уу

- A. Шарын хурц халуу бэлгэ чанар арвидах

- V. Хийн хөнгөн хөлбөрөнгүй бэлгэ чанар арвидах
  - C. Бадганы хүнд сэрүүн бэлгэ чанар арвидах
  - D. Ходоодны галын гурван хүч хямралдах
  - E. Бадганы мохдог, тослог бэлгэ чанар арвидах
- /102./ Хорхойн бэтэг өвчний орших орныг тогтооно уу?
- A. Ходоод
  - B. Бөөр
  - C. Цөс
  - D. Элэг
  - E. Уушиг
- /103./ Гэдэс халууны гэмээр суулгах үед өгөх жорыг сонгоно уу
- A. Гагол-4
  - B. Сэнгэр-15
  - C. Сожид
  - D. Баатар-7
  - E. Шижид-6
- /104./ Ам замаарах, ходоод цанхайх, хэхрэх, бөөлжих, нүд нүүр сэлхрэх, юу эс шингэсэн нь илүү хорлох нь ямар өвчний шинж болохыг тогтооно уу
- A. Цөв эс шингэсэн
  - B. Тунгалаг эс шингэсэн
  - C. Бадган салс , хэхрэх, хөших, хор мэт
  - D. Хий, шар , бадгантай хавсарсан
  - E. Хуйлрах, тогтох, цувирах, сарних
- /105./ Халуун өвчнийг засах гол зарчмыг тогтооно уу.
- A. Настай нь уялдуулж засах
  - B. Шарыг дарж цусыг шингэлэх
  - C. Халуун өвчний тухайн цагийг үндэслэх
  - D. Махбодыг тэгштгэх
  - E. Оронтой нь уялдуулан засах
- /106./ Дараах үесээс найман гишүүнтэд багтах ангилалын өвчний тодорхойлно уу
- A. 3 гэгийг анагаах
  - B. Мэсийн шархыг анагаах
  - C. Дотор өвчнийг анагаах
  - D. Халуун өвчнийг анагаах
  - E. Хэсэг бусаг өвчнийг анагаах
- /107./ Шар өвчний шээсний өнгөний онцлог шинжийг тогтооно ууц
- A. Тод шар өнгөтэй
  - B. Цөөрмийн ус шиг хөхөвтөр
  - C. Цагаан өнгөтэй
  - D. Тод улаан өнгөтэй
  - E. Энгэсгийн зайлдас мэт өнгөтэй
- /108./ Элэгний ам цалгивал аль аль эрхтэнд нөлөөлхийг тогтооно уу
- A. Цөс
  - B. Уушиг
  - C. Гэдэс
  - D. Дэлүү
  - E. Зүрх
- /109./ Бөөрөнд булингартсан халуун буусан үеийн эмчилгээг сонгоно уу
- A. Эхлээд брагшун 9 өгч ханана
  - B. Брагшун, башига, наймаалж, ар үр, шар мод өгөх
  - C. 11 – р үеийг төөнөх

- D. Бөөрний ар үр 10 өгөх
  - E. Марав 3 өгөх
- /110./ Брай өвчин үсэрхийлэхээс сэргийлж аль найрлагыг сонгохыг тогтооно уу
- A. Гүргэм , баавгайн цөс, жонш өгөх
  - B. Баавгайн цөс, 2 төрлийн үнс, балчирганы өтийг бурамтай үрэлдэж өгөх
  - C. Гиван, домьти, өвсөн гүргэмийг тарагтай үрэлдэж өгөх
  - D. Жуган, гүргэм, домьти , тунсааг чихэртэй үрэлдэж өгөх
  - E. Гурван үр өгөх
- /111./ Махны хэрх өвчний үед илрэх шинжийг олно уу?
- A. Өвдөлт маш их, хөдөлж чадахгүй
  - B. Хөшиж өвдөх, хөдөлгөөн хязгаарлах
  - C. Мах, яс салах мэт өвдөх
  - D. Мах тасрах мэт
  - E. Том үе өвдөх
- /112./ Шээс улайж, цанх хөдлөх мэт өвдөх нь ямар эрхтэний гэмтсэн халуун болхыг олно уу
- A. Гэдэс
  - B. Цөс
  - C. Давсаг
  - D. Ходоод
  - E. Олгой
- /113./ Шар хураагдсаны шинжийг тодорхойлно уу
- A. Нүд, шээс шарлах, ам гашуу оргих
  - B. Нүд, шээс , нүүрний өнгө урьдахаас цайх
  - C. Нүд, шээс , нүүр цайвар
  - D. Нүд, шээс , царай харлах
- /114./ Усан сааны үүсэх шалтгааныг тодорхойлно уу?
- A. Хий бадганы урвалтаар цагаан судас гэмтэх
  - B. Шарын урвалтаар цагаан судас гэмтэх
  - C. Мэдрэхүйн сүв хаагдснаас үүсэх
  - D. Шар усны гэмээс болох
  - E. Элэгний шар хөөх
- /115./ Үргэлжлэн ханиалгаж, цэр ховхрохдоо муу, өглөө үдэш сэвсгэр хөөстэй багахан цэртэй ханиалгах нь уушигны ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу
- A. Цайвар хаван
  - B. Дагшиж ханиах
  - C. Уушгины халуун
  - D. Ус алдах
  - E. Огшрон ханиах
- /116./ Ямар амт чадалтай идээг хэтрүүлэн хэрэглэвэл хий өвчин үүсч болохыг тогтооно уу
- A. Гашуун, хөнгөн, ширүүн
  - B. Халуун, исгэлэн, давслаг
  - C. Гашуун, амтлаг, хүнд, сэрүүн, тослог
  - D. Халуун эхүүн тослог
  - E. Исгэлэн, амтлаг, хүнд, сэрүүн
- /117./ Ундаасах өвчний үед ямар махбод хямрахыг тогтооно уу
- A. Бадгана, хий
  - B. Хий шартай хавсрах
  - C. Дээш гүйгч хий шартай хавсрах
  - D. Түгмэл гүйгч хий бадганатай хавсрах
  - E. Цус шар хавсрах
- /118./ Шар усны өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу



- A. Хөндий хоосон үе үе зогсох
- B. Нарийн эрчимтэй
- C. Живэнгүй дорой
- D. Товойж хуйлрах
- E. Чичирч гүйхэд бэрх

/119./ Эс шингэсэн өвчнийг үүсгэж болох үл зохих идээ нь аль болохыг тодорхойлно уу

- A. Мах, цай
- B. Айраг, мах
- C. Өндөг, загасны мах
- D. Боловсроогүй үр жимс, цай
- E. Түүхий ногоо ,түүхий сүү, загасны мах

/120./ Хэрх өвчний эмчилгээнд шар усыг хатаах найрлагууд гол болж хэрэглэгдэнэ. Яагаад гэвэл хэрх өвчин бол шар усны гэмээс шалтгаалж үүсдэг. Өөрөөр хэлбэл өвчний эмгэг жам нь тунгалаг орондоо хэвийн боловсорч чадаагүйтэй холбоотой явагддаг.

/121./ Зогсох өвчин нь хэсэг бусад өвчний ангилалд багтдаг бөгөөд энэ өвчний үед дээш гүйгч хий хямардаг. Яагаад гэвэл дээш гүйгч хий нь хэвийн үед амьсгал авхуулах яриулах үйл үйлдэнэ

/122./ Эс боловсорсон халууныг боловсруулахгүйгээр эмчилбэл нуугдах, хуучрах, дэлгэрэх, хоосрох мэтээр бусад өвчинд шилждэг. Ийм учраас сайн боловсруулбал анагаахад хялбар бөгөөд эдгэх нь ч түргэн байдаг. Үүний тулд зөвхөн Мана-4-г тав хоног өгөх хэрэгтэй юм.

/123./ Хүйтэн чанартай усан хаван нь элэгний борын бэтгээс үүсдэг. Яагаад гэвэл элэгний өвчнүүд архагшиж удсанаас хүйтэнд шилждэг. Ийм учраас энэ өвчний үед сарнисаныг хураах зарчмаар жүр үр -6 сонгодог

/124./ Тулай өвчин удаж хуучирвал өвчин бүлх, яс үест түгэж эхэлдэг. Яагаад гэвэл энэ нь шинэхэн үүссэн муу цусны гэмээс шалтгаалж байгаа хэрэг юм. Ийм учраас энэ үед сэмагийн танг эмчилгээнд хэрэглэх шаардлагатай.

/125./ Өвчтнийг үзэхэд шээс нь улбар шар өтгөн булингартай, хэл нь цайвар өнгөртэй дээр нь хийн улаан гөвдрүүтэй байлаа. Энэ өвчнийг хэрэгт дөрвөн товчооны үүднээс авч үзвэл гаднаа халууны хуурамч шинж бүхий мөн чанар нь халуун өвчин юм. Ийм учраас бүрхүүл хуулах эмчилгээний зарчмыг сонгоно.

/126./ Булингартсан халууны шалтгааныг бадган гэж үздэг. Ийм учраас хураах зарчмын дагуу түлсэн давсны найрлагыг хэрэглэнэ. Яагаад гэвэл энэ жор нь муу цусыг тамирын цус болгох эрдэмтэй

/127./ Хуучирсан халуун өвчин нь архаг явцтай үндэснээс гаргаж засахад бэрхтэй өвчин. Ийм учраас сарнисныг хураах зарчмын хүрээнд эмчилгээг хийнэ. Үүнд жонлон-5г өгч хурсан шинж илэрмэгц танчин -10 аар нядлах нь хорын модыг үндэснээс гаргах мэт эмчилгээ болдог.

/128./ Чацга нь шар өнгөтэй хурц үнэртэй байгаа тул индра - 4, барагшун - 9 жорыг сонгох шаардлагатай. Яагаад гэвэл энэ нь шарын гаралтай суулгалт байгаа бөгөөд өвчний урхагийг гаргах зорилгоор нэмж данрог-5-р туулгавал зохино.

/129./ Дэлгэрсэн халуун өвчин үүсэхэд цагийн нөхцөл голлоно. Ийм учраас бүрхүүл хуулах зарчмаар сэрдог -5 сонгоно. Яагаад гэвэл сэрдог 5 дэлгэрсэн халууныг анагаах анагаах хүйтэн чанартай найрлага юм

/130./ Хар тулай өвчний эхний үед цус шар дийлэнх байдаг учраас эмчилгээний эхэнд цагаан гүгэлийг сүүтэй найруулж өгөхөөр заасан байдаг. Яагаад гэвэл энэ найрлага нь өвдөлт намдаах шар ус хатаах үйлдэлтэй.

/131./ Ерөндөг-7 нь бор өвчнийг анагаах үндсэн найрлага. Энэ эм нь борын гурван цагийн хүйтэн шатанд хамгийн тохиромжтой. Яагаад гэвэл энэ үе шатанд үүссэн бэтгийг эвдэх зорилгоор хэрэглэнэ

/132./ Эс боловсорсон халуун сарнисан үед борвины ясны шөл, гурван үрийн ширгээсэн тан, 6-н сайны талх эмүүдийг өгөхөөр заасан. Яагаад гэвэл нь найрлагууд сэрүүн шимт хосолсон учраас хураах үйлдэлтэй юм.

/133./ Хуучирсан халуун өвчин бол тамир бүхэнд шунаж удаж архагшсан өвчин. Ийм учраас боловсруулах зарчмын дагуу гагол - 4- ийг хэрэглэнэ . Яагаад гэвэл энэ найрлага нь өвчнийг боловсруулах гол тан юм

/134./ Хуйларсан хэлбэрийн борыг дотор нь нэвчирсэн эс нэвчирсэн гэж ангилдаг. Ийм учраас бүрхүүл хуулах зарчмаар гантиг – 9 сонгож эмчилдэг. Гантиг 9 нь нэвчирсныг зогсоох үйлчилгээтэй юм

/135./ Эс боловсорсон халуун өвчний үндсэн шалтгаан бол бадган хий юм. Яагаад гэвэл халууны хүч нь товойж гарч чадаагүй байгаа өвчний цус тамирын цус нь сүү ус нийлэлдсэн мэт байгаа өвчний нуугдмал үе. Ийм учраас дайсныг дарах зарчмаар эмчлэх ёстой.

/136./ Муу шар усны гэмээс шалтгаалж үүссэн тулай өвчний дэлгэрч байгаа үед өвчин ерөнхийдөө арьс цусанд оршиж байдаг. Учир нь энэ үед хий цусны хямрал илүү ява гддаг.

/137./ Шар ус нянгаас шалтгаалж халдвар дамжих замаар үүсдэг шинэ хэрх өвчнийг “ Манаглхантав “ сударт лидэр, 3 үр, сэндэн, бугын эврийн тангаар засахыг номлосон байдаг. Учир нь энэ тан бол эс боловсорсон үе шатанд боловсруулах зорилгоор хийх эмчилгээ юм.

/138./ Халуун өвчний үед хийгддэг хөлөргөх заслыг дотроос хөөх, гаднаас татах хэмээн хоёр ангилдаг. Дотроос хөөх нэг найрлага нь Лидэр - 7 болно. Яагаад гэвэл энэ найрлагыг тамир дорой хүнийг хөлөргөхөд өгөхөөр заасан байдаг.

/139./ Хэрх өвчин нь муу шар уснаас шалтгаалж үүсдэг. Ийм учраас эхний 5 хоногт Жонлон - 5 танг өгөхөөр заасан. Энэ найрлага нь бадган шар усны гэмийг арилгах үйлдлийг үзүүлдэг .

/140./ Нуугдсан халуун өвчин бол гаднаа хуурамч хүйтэн шинж бүхий мөн чанар нь халуун өвчин. Энэ өвчнийг тус бүрээр нь 3 ангилж үздэг. Яагаад гэвэл энэ ангилалын хүрээнд хамаарах эрхтэнүүдэд бадган хий голлон гүйнэ.

/141./ Суулгах өвчний үед уруу арилгагч хийн үйл ажиллагаа хямардаг. Яагаад гэвэл энэ нь хангагч бадганы хямралаар сэдээгдэж байгаа юм . Ийм учраас гэдэсний хатгалгыг анагаах зарчмаар эмчлэнэ

/142./ Халууны өвчний сүүлд хий үүсч хоосорсон халуун өвчнийг үүсгэх магадлал өндөр байдаг. Ийм учраас өвчний бүрхүүлийг хуулах зарчмаар чуна- 5 сонгоно Яагаад гэвэл энэ найрлага нь хий, халууныг хамтад нь дарах эрдэмтэй байдаг.

/143./ Хүч ихтэй удаан хугацаагаар зогисох нь хэсэг бусгаг зогисох өвчний ангилалд багтдаг. Энэ үед гал тэгшитгэгч хий хямардаг. Ийм учраас гал тэгшитгэгч хийн хямралыг тэгшитгэх зарчмаар хүчтэй туулга хэрэглэнэ

/144./ Онолын үндэст хошногны амсраас дотогш 1 хуруу хагаст байх атирааг завсрын атираа гэж заасан. Энд үүссэн шанбарамыг эдгэхэд хялбар хэмээн сурвалжид тэмдэглэсэн байдаг. Ийм учраас Гаранза-6 танг өгөхөд үр дүн сайтай байдаг.

/145./ Борын өвчний үед ямар ч шалтгаангүйгээр халуун исгэлэн усаар бөөлжих шинж гардаг. Яагаад гэвэл борын өвчнийг үүсгэхэд олон төрлийн шалтгаан ордог учраас өвчнийг хөдөлгөх нөхцөл тодорхой бус байдаг. Энэ шинжийг борын 3 цагийн навч гэдэг шинжид хамааруулдаг.

/146./ Цайвар хаван өвчний үед хэрэглэх идээ ундааг тодорхойлно уу

A. Загасны мах

B. Ямааны мах

C. Тутрага

D. Гахайн мах

E. Шинэ бурам

/147./ Олгой хүйтнээр дүүрэх өвчний гол шинжийг олно уу?

A. Ам хатах

B. Бөөр бэлхүүсээр тасрах мэт өвдөх

C. Өтгөн хатах

D. Цайвар өнгөтэй зүйл эсвэл идээний өнгөөр суулгана

E. Өвдөлтгүй суулгана

/148./ Гал сацуу хийн гүйх мөр хаагдснаас дотор хөөж дүүрэх, байнга зовиурлах, хэхэрч чадахгүй болох нь ямар өвчний эс шингэсэн өвчний шинж болохыг тогтооно уу

- A. Эс шингэснээр хэхрэх
- B. Эс шингэснээр хөших
- C. Эс шингэсэн бадгана салс
- D. Эс шингэсэн хор мэт
- E. Тунгалаг эс шингэсэн

/149./ Төв судасны эрхтэнийг оронд нь ургуулах судас хаана байрладгийг тогтооно уу

- A. Бэлгэст
- B. Зүрхэнд
- C. Хүйсэнд
- D. Тархинд
- E. Үе мөчинд

/150./ Шар усны өвчний шээсний өнгөний онцлог шинжийг тогтооно уу

- A. Тод шар өнгөтэй
- B. Цөөрмийн ус шиг хөхөвтөр өнгөтэй
- C. Цагаан цайвар өнгөтэй
- D. Тод улаан өнгөтэй
- E. Энгэсгийн зайлдас шиг өнгөтэй

/151./ Шингэсэн оронд бор дэлгэрвэл ямар шинж илрэхийг тодорхойлно уу

- A. Харавтар өнгөтэй цусаар суулгана
- B. Утааны шүүс мэт зүйлээр бөөлжинө
- C. Энгэсгийн зайдас мэт зүйлээр бөөлжинө
- D. Шар өнгөтэй зүйлээр суулгана
- E. гэдэс мушгирч эс шингэсэн зүйлээр суулгана

/152./ Номлохуйн үндэст зааснаар өвчнийг ёсчлон ялгах гэсэн нь аль болохыг тогтооно уу

- A. өвчин өөр, өөрийнх нь үүсгэх нөхцөлтэй учрах
- B. өвчний шинж тодорхой болсон үе
- C. өвчнийг дотор зуураар нь ялгах
- D. өвчний шинж тэмдэг тодроогүй үе
- E. өвчний хүч

/153./ Бөөр бэлхүүс нь янгинаж тахим нь татах шинжээр илэрдэг элэгний ямар өвчин байдгийг тогтооно уу

- A. Үхэр бөгтөр
- B. Элэг дэлгэрэх
- C. Гол хөших
- D. Элэгний хар хэрх
- E. Элэгний хий

/154./ Бүрхүүл хуулах эмийг тогтооно уу?

- A. Жуган 25
- B. Анар 4
- C. Анар 8
- D. Гавар 25
- E. Ар үр 10

/155./ Гүргэм - 7, Жуган - 8 өгөхийн зэрэгцээ ханах заслыг ямар цанх өвчний үед өгөхийг сонгоно уу

- A. Дэлүүний цанх
- B. Элэгний цанх
- C. Уушгины цанх
- D. Савны цанх
- E. Ходооны цанх

/156./ Өвчтөний судас барихад урьдчилан хийх бэлтгэл юу байдгийг тогтооно уу?

- A. Хоол их идэх

- V. Бие хэл сэтгэлийн үйлийг хэвийн байлгах
- C. Халуун ногоо харьцангуй мх хэрэглэх
- D. Жимс ногоо сайн идэх
- E. Ходоод угаах

/157./ Цус хямарсан дан халуун өвчин аль нь болохыг тогтооно уу

- A. Зөөлөн хямрах
- B. Хямран дэлгэрэх
- C. Халуун хижиг
- D. Хор харших
- E. Хурмал хижиг

/158./ Дур амаргүй болох, цээжээр тэлэгдэх, ар өврөөр хатгуулах, дотор халах, исгэлэн усаар гулгих, дур хаагдах нь ямар бадган өвчний үед илрэх шинж болохыг тодорхойлно уу

- A. Ялзлагч
- B. Амсуулагч
- C. Барилдуулагч
- D. Хангагч
- E. Шүтүүлэгч

/159./ Сарын хирийн мөчлөг алдагдаж хар өнгөтэй эвгүй үнэртэй зүйл гарах, хэвлийн доод хэсгээр базалж өвдөх, халуурах шинж бүхий умайн өвчин нь ямар махбодын хямралаас үүссэн болохыг тогтооно уу

- A. Хийнээс
- B. Цуснаас
- C. Шараас
- D. Бадганаас
- E. Хурмалаас

/160./ Цуснаас болсон дуу хаагдах өвчний үед ямар засал хийхийг тодорхойлно уу

- A. Тосон жин тавих
- B. Жүр үрийн тан өгч бугуйн судсыг ханах
- C. Төөнөх
- D. Молор давсыг хамрын эм болгох
- E. Бөөлжүүлэг засал хийж төөнөх

/161./ Эс боловсорсон халууныг засах ерөнхий зарчмыг тогтооно уу

- A. Шууд нядлах
- B. Туулгах
- C. Боловсруулах
- D. Эхлээд лидэр, гандигарын тан өгөх
- E. Дунд үед нь халуун нурам руу ус цацах мэт засах

/162./ Усан сааны үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу

- A. Бие илчгүй болно
- B. Ам цангах
- C. Хэлний баруун тал охор
- D. Биеийн баруун тал суларна
- E. Хумс шарлана

/163./ Хямарсан халууны судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу?

- A. Балархай бөгөөд чичирч таталдана
- B. Бүдүүн дэлгэрэнгүй товойж хуйлрана
- C. Нарийн чанга эрчимтэй
- D. Нарийн түргэн
- E. Огцом лугших

/164./ Өвчнийг үзэхэд дуу нь өндөр нам болно. Хоолойд өргөс орсон юм шиг санагдаж байна хэмээн зовиурлана. Үзэхэд халуунтай байсан ямар дуу хаагдах өвчний шинж болохыг тогтооно уу

- A. Шараар дуу хаагдах
  - B. Бадганаар дуу хаагдах
  - C. Хийгээр дуу хаагдах
  - D. Цусаар дуу хаагдах
  - E. Барагдуулагчаас болох
- /165./ Халуун чанартай усан хаван үүсэх өвчин зүйн хувиралтыг тогтооно уу?
- A. Гэдэснээс нэвчирч үүсэх хаван
  - B. Шээс цугларч үүсэх хаван
  - C. Тунгалгийн ус сарниж үүсэх
  - D. Цус сарниж үүсэх
  - E. Ходоодноос нэвчирч үүсэх
- /166./ Өтлөгсдийг тэнхрүүлэхэд 5 тунгалгийг хэрэглэх тухай сурвалж зохиолд заасан байдаг.Түүний нэг болсон модны тунгалаг бурам юуны тэжээл болохыг тогтооно уу
- A. Ясны тэжээл
  - B. Махны тэжээл
  - C. Өнгөний тэжээл
  - D. Шимийн тэжээл
  - E. Хүчний тэжээл
- /167./ Тунгалаг эс шингэсэн өвчний үед ямар шинж илрэхийг тогтооно уу
- A. Дур хаагдах, дотор алжаах,мах хатингартах, зүрх хавиргаар өвдөх
  - B. Гашуун исгэлэн усаар гулгих, гэдэс дүүрэх
  - C. Хоолны шингээлт муудах, шар зүйлээр суулгах
  - D. Дотор хөөх, халуун хүйтэнд тэсэшгүй өвдөх
  - E. Толгой эргэх, чичирч амьсгаадах,үе мөч хөших
- /168./ Хүчжүүлэх заслыг хэрэглэхэдхийхэд өмнөх бэлтгэл нь юу болохыг тогтооно уу
- A. Тосон засал угаалга, нируха
  - B. Таван рашаанд орох, туулга
  - C. Бөөлжүүлэг, зөөлөн шимт
  - D. Судсан туулга
  - E. Жин төөнүүр, угаалга
- /169./ Шээсний язмаг хаанаас үүсч бүрэлддэгийг тодорхойлно уу
- A. Цөсний тунгалаг
  - B. Өнгө урвуулагч шар
  - C. Цусны цөв
  - D. Цөсний цөв
  - E. Тунгалгийн цөв
- /170./ Бадган өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу
- A. Хөх өнгөтэй, том хэмжээтэй дуугарч хагарна
  - B. Шар өнгөтэй жижиг, түргэн арилна
  - C. Шүлс хаясан мэт хөөстэй, наалдамхай
  - D. Улаан хөөстэй түргэн арилна
  - E. Хөөс нь солонгорно
- /171./ Бор нуугдвал ямар шинж илрэхийг тогтооно уу
- A. Хатгуулж өвдөх
  - B. Шээс улайх
  - C. Судас нарийн түргэн
  - D. Судас живэнгүй, шээс ногоовтор, бие хүндрэх
  - E. Хавагнах, зүрх дэлсэх
- /172./ Идээ, ундаанд дургүй болох, амьсгал амаргүй болох бөгөөд хамуу, чихига, хулгана яр, цайвар хаван, гал намс, нүдний өвчин, ханиад хижиг болж хүндрэх нь аль хэсэгт хамаархыг тогтооно уу
- A. ундаасахыг хаах

- В. өлсөхийг хаах
- С. хийлэхийг хаах
- Д. цэрийг хаах
- Е. бөөлжихийг хаах

/173./ Хий шар бадган хямарч биеийн тунгалаг гүйх сүв хаагдаж галын илч буурах эмгэг жамаар үүсдэг уушигны ямар өвчин байдгийг тогтооно уу

- А. Их архаг
- В. Цайвар хаван
- С. Барагдуулагч их архаг
- Д. Суръяа
- Е. Брай

/174./ Бүрхүүл хуулагдсаны дараа ямар эм өгхийг тогтооно уу

- А. Агар 15
- В. Жуган 25
- С. Манагсэлжор
- Д. Зову 8
- Е. Зову 25

/175./ Хүйтэн цанх өвчний үед илэрдэг шинж тэмдгийг сонгоно уу?

- А. Судас нарийн эрчимтэй
- В. Шар өнгөтэй зүйлээр бөөлжих
- С. Үмхийгээр хэврүүлэх
- Д. Ходоод хэвлийгээр ороож бүсэлж өвдөх
- Е. Ам хатах

/176./ Эмчийн баруун гарын дунд хуруунд өвчтөний ямар цул сав эрхтэний судасны лугшилт мэдрэгдэхийг тодорхойлно уу

- А. Элэг,цөс
- В. Бөөр,давсаг
- С. Зүрх,гэдэс
- Д. Уушги,олгой
- Е. Дэлүү, ходоод

/177./ Уушгинд халуун бүрхэгдсэн үед ямар шинж илрэхийг тогтооно уу

- А. Цэр нь утааны шүүс шиг
- В. Цэр гарахгүй хоригдох
- С. Уруул цайх
- Д. Цусаар ханиах
- Е. Сэвсгэр хөөстэй цэр гарна.

/178./ Хэрх өвчний онцлог шинжийг тогтооно уу

- А. Шээс хаагдах
- В. Амьсгаа давхцах
- С. Улбар шар цэртэй ханиах
- Д. Амархан хөлөрч, хөдөлгөөн хийхэд өвдөх, мах үес шархирах
- Е. Нүд улайж, цээжээр хатгах

/179./ Сарын хир үргэлжлэн цувирч их хэмжээтэй гарах нь ямар махбодоос шалтгаалсан болохыг тогтооно уу

- А. Хийнээс
- В. Цуснаас
- С. Шараас
- Д. Бадганаас
- Е. Хурмалаас

/180./ Шарын бэтгийн үед ямар засал эмчилгээний үр дүнтэй болохыг тодорхойлно уу?

- А. Туулга

- В. Бөөлжүүлэг
- С. Тосон засал
- Д. Эмээр эвдэх
- Е. Хатгуур

/181./ Боловсрох чөлөөгүй халууны эмчилгээг сонгоно уу

- А. Эрдэнэ 7 өгөх
- В. Шарын цагт нь гавар 3 өгөх
- С. Гурван шимт ясны тан өгөх
- Д. Бадгана хийн цагт нь анар 4 өгөх
- Е. 4 гаргалт өгөх

/182./ Хар бам өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу?

- А. Хавдар нь цайвар өнгөтэй
- В. Хавдар нь хөх өнгөтэй
- С. Нүүр царай нь хөхөрч борлоно
- Д. Үе мөч хатингартана
- Е. Бие ядарч сульдана

/183./ Хижгийн халууны судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- А. Балархай бөгөөд чичирч таталдана
- В. Бүдүүн дэлгэрэнгүй товойж хуйлрана
- С. Нарийн чанга эрчимтэй
- Д. Нарийн түргэн
- Е. Огцом лугших

/184./ Шар усны өвчний үед ямар онцлог шинж илэрдгийг тогтооно уу

- А. Загатнаж гүвдрүү гарах
- В. Гар хөл хүйт оргих
- С. Дээш хөөрөх
- Д. Хамраас цус гоожих
- Е. Зүрхээр өвдөх

/185./ Усан хаван өвчний боловсрох үе шатанд илрэх шинж тэмдэг аль болохыг тогтооно уу

- А. Хэл, буйл цайх
- В. Хэвлийгээр өвдөх
- С. Үе мөч хатингартах
- Д. Шингээлт муудах
- Е. Цавинд дарвал хаван мэдэгдэх

/186./ Дэлүүний суулгах өвчний шинжийг олно уу?

- А. Шар өнгөтэй зүйлээр суулгана
- В. Хөөсөөр суулгана
- С. Эс шингэснээр суулгана
- Д. Өөх тосоор суулгана
- Е. Эс шингээгүй зүйлээр суулгана

/187./ Хоол унд сойж өглөө үдэш жамц давстай ус уулгах эмчилгээ ямар хэлбэрийн эс шингэсэн өвчинд тохирхыг тогтооно уу

- А. Хүч бага эс шингэсэн
- В. Дунд зэргийн хүчтэй эс шингэсэн
- С. Хүч ихтэй эс шингэсэн
- Д. Тунгалаг эс шингэсэн
- Е. Цөв эс шингэсэн

/188./ Халуун чанартай хорын өвчнийг анагаахад туслах идээ ундааг тогтооно уу?

- А. Битүү туурайтны мах
- В. Үхрийн шинэ мах
- С. Исгэлэн ногоо

- D. Гахайн мах
- E. Хонины мах

/189./ Хар зурхайн онол ёсоор ямар цул сав эрхтэнүүд эх-хүүгийн (эх@хүү) харьцаанд оршдогийг тодорхойлно уу

- A. Зүрх гэдэс @ элэг цэс
- B. Дэлүү ходоод @ уушиг олгой
- C. Бөөр давсаг @ зүрх гэдэс
- D. Уушиг олгой @ элэг цэс
- E. элэг цэс @ бөөр давсаг

/190./ Шар өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу

- A. Хөх өнгөтэй, хөөс нь том хэмжээтэй дуугарч хагарна
- B. Шар өнгөтэй жижиг хөөстэй, түргэн арилна
- C. Шүлс шиг хөөстэй, наалдамхай
- D. Улаан хөөстэй түргэн арилна
- E. Хөөс нь солонгорно

/191./ Бор өвчин нуугдаж тогтсон үед ямар эмчилгээ үр дүнтэй болохыг тогтооно уу

- A. Бадганыг эмчлэх
- B. Халууныг боловсруулах
- C. 6 сайн ба жоншны найруулгаар эвдээд суулгана
- D. Цус шарын халууныг дарах
- E. илч сэлбэж төөнөөр хавцлыг боох

/192./ Халуун, хурц чанартай бөгөөд туранхайг маариажуулан, тарганыг шууруулан чийрэгжүүлэх, бадган, хийг арилгах үйлдэлтэй тосыг сонгоно уу.

- A. гүнжидийн тос
- B. чөмөгний тос
- C. гичийн (юнгарын ) тос
- D. өөх
- E. шар тос

/193./ Бөөрний ус алдах өвчний үед жүр үрийг ямар зарчим дээр үндэслэн өгөхийг тогтооно уу

- A. Усны амыг боох
- B. Шар усыг хатаах
- C. Цус ялгах
- D. Цусны халууныг арилгах
- E. Усыг ялгах

/194./ Хуучирсан халуун өвчин үүсэх ёсыг тогтооно уу

- A. Шарын халуун тамирт шунаснаас үүсэх өвчин
- B. Тамир бүхэнд халуун сарнисан өвчин
- C. Идээ явдлын буруудлаар цус, шар хямрах өвчин
- D. Хий, цус хямарсан өвчин
- E. Цус, шар хямарсан өвчин

/195./ Хэрх өвчний үед бадган шар усыг арилгах зорилгоор эхний 5- н өдөр ямар эмчилгээ хийхийг тогтооно уу

- A. Хэрхийг мөрөөс буцаагч тан
- B. Мөнгөн усны талх эмийг өгөх
- C. Төөнө засал
- D. Шавар эмчилгээ
- E. Дэвтээлгэ засал

/196./ Эм судасны лугшилтийн онцлогийг тогтооно уу

- A. Нарийн эрчимтэй
- B. Нарийн түргэн
- C. Нарийн дэлгэрэнгүй



- D. Нарийн чанга
  - E. Нарийн дорой
- /197./ Хуучирсан халуун судсанд гүйсэн бол ямар эмчилгээ хийхийг тогтооно уу
- A. Хэвлийн туулга өгөх
  - B. Судлыг дагуулан төөнөх
  - C. Хуучирсан халуун гүйсэн судлыг шууд ханах
  - D. Зандан 11 өгч аль дэлгэрсэн судлыг ханах
  - E. Оюу – 8 өгөх
- /198./ Амь баригч хий хямархад ямар шинж илрэхийг тодорхойлно уу
- A. Ам муруйж эрхтэний мэдэрхүй буурах, хэлгийрэх, чулчрах, тамир багасах
  - B. Амьсгаа авахад хүчлэх, залгиж чадахгүй, зүрх түгших, толгой эргэх
  - C. Зүрх мушиграх мэт санагдах, айх, үг олшрох, манарах
  - D. Баас, шээс хоригдох, үес өвдөх, доголох
  - E. Шингэхэд бэрх, идээнд үл дурлах, бөөлжих, ходоод хүйт оргих
- /199./ Загатнах доод бие хүйт оргиж, ууц нуруугаар чилж өвдөх, доошоо цагаан юм гарах нь умайн өвчин ямар махбодын хямралаас болж үүссэн болохыг тогтооно уу
- A. Хийнээс
  - B. Цуснаас
  - C. Шараас
  - D. Бадганаас
  - E. Хурмалаас
- /200./ Зүрхний халуун дэлгэрэх өвчний өвдөлтийн онцлог шинжийг тодорхойлно уу
- A. Маш хүчтэй базалж өвдөнө
  - B. Хадаасаар хатгах мэт өвдөнө
  - C. Зүрх мушиграх мэт өвдөнө
  - D. Цээжин дээр гал тавьсан мэт төөнөж өвдөнө
  - E. Хутгаар хэрчиж буй мэт өвдөнө
- /201./ Бам өвчний хэлэнд гарах өөрчлөлтийг сонгоно уу
- A. Улаан хуурай ширүүн
  - B. Шар өнгөртэй
  - C. Зузаан цайвар өнгөртэй
  - D. Эрээн хар алаг, өнгөртэй болох
  - E. Шүдний ором гарах
- /202./ Найруулсан хорын өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу?
- A. Нарийн түргэн балархай живэнги
  - B. Ширүүн долгисож солилцон лугшина
  - C. Нарийн түргэн хөлбөрөнгүй
  - D. Хатуу эрчимтэй
  - E. Хоосон түргэн
- /203./ Цайвар хаван өвчин үүсэх ёсыг тогтооно уу
- A. Муу цус биед хийгээр тархаах
  - B. Шар усыг биед хийгээр тархаах
  - C. Эс шингэсэн тунгалаг муу цус, шар ус биед тархах
  - D. Биед бадган салс хуримтлагдснаас
  - E. Цөс биед тархах
- /204./ Зүрхний ямар эм ууснаа мэдэхгүй байна гэсээр өвчтэн ирсэн, түүний зүрхний цохилт минутанд 80-аас дээш болсноос гадна ам, хэл бадайрах, дотор муухайрах зэрэг шинжүүд илэрсэн байна. Өвчтөн ямар эм уусан байж болохыг тодорхойлно уу?
- A. 3 үрийн тан
  - B. Агар 8
  - C. Соргозон 11

D. Мана 4

E. Чуна 5

/205./ Хэврүүлэх, хоосноор огиулах базлах мэт өвдөх, хоржигнон суулгах нь ходоодны ямар өвчний шинж болохыг тогтооно уу

A. Ходоодонд шар унасан

B. Ходоод тэлэгдсэн

C. Ходоод доройтсон

D. Ходоодны хий

E. Ходоодны бадгана

/206./ Өвчтнийг үзэхэд хоолой сөөж дуу доор болсон байв. Ямар махбод хямарснаас үүссэн дуу хаагдах өвчин болохыг тогтооно уу

A. Шараас болсон дуу хаагдах

B. Бадганаас болсон дуу хаагдах

C. Хийнээс болсон дуу хаагдах

D. Цуснаас болсон дуу хаагдах

E. Барагдуулагчаас болсон дуу хаагдах

/207./ Өвчтөний бие нь хөнгөрөн хөлрөх нь зогсох, сэтгэл амгалан болж биеийн хүч нэмэгдвэл хорын өвчний ямар хувиралт болохыг тогтооно?

A. Өвчин боловсрох

B. Өвчин хувирах

C. Өвчин сарних

D. Өвчин эдгэх

E. Өвчин хүндрэх

/208./ Дэлүүний цусаар хөөх өвчний онцлог шинжийг тодорхойлно уу

A. Уруулд өнгөр тогтох

B. Шингээлт муудаж хэврэх

C. Нүүр шарлаад хөөж хоржигнох

D. Нүүр борлох

E. Хатгуулах

/209./ Хорын өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу

A. Хөх өнгөтэй, хөөс нь том хэмжээтэй дуугарч хагарна

B. Шар өнгөтэй хөөс нь жижиг, түргэн арилна

C. Шүлс шиг хөөстэй, наалдамхай

D. Улаан хөөстэй түргэн арилна

E. Хөөс нь солонгорно

/210./ Сарнисан бор өвчин хураагдсны шинжийг тогтооно уу?

A. Бие хүндрэх ам хатах, судас шээсэнд халууны шинж илрэх дур хаагдах

B. Цусаар гүйлгэж, цээж хорсох ам гашуурах

C. Хоолны шингээлт муудах, хөл гар минчүүрэх

D. Толгой эргэх, хэвлий хөөх

E. Нүд нүүр цайх

/211./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Номлохуйн үндэс”-т заасанчлан бадган өвчний үе дэх эм уух ёсыг сонгоно уу?.

A. Идээний өмнө

B. Идээ эс идсэн цагт

C. Идээний дунд

D. Идээний эцэст

E. Идээний завсарт

/212./ Бөөр доргих өвчний үед ямар махбод илүү хямралдахыг тогтооно уу

A. Цус

B. Шар

- C. Хий
- D. Бадган
- E. Хорхой

/213./ Хуучирсан халууны эмчилгээний зарчмыг тогтооно уу?

- A. Цус шарын халууныг арилгах
- B. Махбод тэгшитгэх
- C. Дунд үед нь халуун нурам руу ус цацах мэт зарчмаар эмчлэх
- D. Сүүлд нь зөөлөн ерөндгөөр халууны урхаг гаргах
- E. Тамирт шунасан халууныг эхлээд хураах

/214./ Цагаан хэрх өвчний үед илрэх шинж тэмдгийг олно уу.

- A. Үений өвдөлт хүчтэй
- B. Үе улайж хавдах
- C. Судас дорой чичрэх
- D. Өндөр халуурах
- E. Шээс уур үнэр их

/215./ Хаврын улирлын эхний 72 хоногт үйл ажиллагаа нь идэвхжсэн эрхтэний судас хэрхэн лугшихийг тогтооно уу

- A. Хитрүүний дуу мэт охор зөөлөн
- B. Хөхөөний дуу мэт бүдүүн уртлаг
- C. Чүүчлын дуу мэт зөөлөн алгуур
- D. Богширгын дуу мэт нарийн эрчимтэй
- E. Бүдэнгийн дуу мэт огцом ширүүн

/216./ Хий дийлэнх эс боловсорсон халуунд засал эртэдвэл хий босно. Энэ үед нь борвины ясны шөлөнд гавар нэмж өгөх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ найрлага нь хий дийлэнх халууныг боловсруулах үйлдэлтэй байдаг.

/217./ Нуугдсан халуун бол гаднаа хүйтний хуурамч шинж бүхий манагдсан гал мэт өвчин. Ийм учраас юуны түрүүнд бүрхүүл хуулах зарчмаар жугандэжидийг сонгох ёстой Яагаад гэвэл энэ найрлага нуугдсан халуун өвчний арьс ч хэлбэрт тохирдог.

